

## Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ

### 1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас хууль тогтоомжийн хэрэгжилт, “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахын зэрэгцээ аймгийн эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, төсөв, санхүүгийн чадавхи, иргэдийн санал хүсэлт, нийгмийн эрэлт хэрэгцээ болон нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудыг улс эх орны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан 2009 оныг аймгийн хэмжээнд **“Төрийн анхан шатны нэгж Багийн үйл ажиллагааг дэмжиж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх”** жил болгон зарлаж, энэ хүрээнд:

1. Төр, захиргааны анхан шатны нэгжийг бэхжүүлэх, албан хаагчдын ёс зүй, чадвар, хариуцлагыг дээшлүүлэх замаар төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлж, төрийн үйлчилээг чанаржуулах,
2. Баг, СӨХ, иргэдийн харилцан уялдаа холбоог сайжруулж, иргэдийн амьдрах орчинг дээшлүүлэх зорилтуудын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллан тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлж ажиллалаа.

### 1.Нийгмийн бодлогын талаар

Боловсролыг олон улсын жишигт ойртуулах зорилгоор Ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх ажлыг эхлүүлж, аймгийн нийт төсвийн зарлагын 54.7 хувь буюу 24.5 тэрбум төгрөгийг Боловсрол, соёлын байгууллагын үйл ажиллагаанд зарцууллаа.

Багшийн хөгжил, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор БСШУЯам, ЭМЯамтай хамтран Зулзагын гол дахь “Багш хөгжлийн төв”-ийг “Багшийн сургалт-сувиллын төв” болгон өргөтгөн зохион байгуулах төслийн ажил хийгдэж байгаа ба энэ арга хэмжээг хэрэгжүүлснээр багш суралцаж хөгжихийн хамт сувилуулах, эрүүл мэндээ хамгаалах асуудал бүрэн шийдэгдэх болно. Энэ нь боловсролыг хөгжүүлэхэд оруулж буй томоохон дэмжлэг болох болно.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Дархан сумын 9-р сургуульд 215.0 сая, Дэлхийн банкны санхүүжилтээр “Од” цогцолборын “Б” байранд 135.0 сая, улсын төсвийн 105.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 12-р сургууль, 1-р цэцэрлэг, Орхон сумын 8-р сургууль, мөн сумын Соёлын төв зэрэг газруудад засварын ажил, 260.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4-р сургуулийн спортын заалыг шинээр барьж ашиглалтад оруулж, нийт 988,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт их засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.

ЕБС-ийн хамран сургалтын хувь 98.3%-д хүрч өмнөх оныхоос 0.3 хувиар, СӨБ-ын байгууллагын хамран сургалт 62.9 хувьд хүрч өмнөх оныхоос 300 хүүхдээр тус тус нэмэгдэж байна. Сурлагын стандарт ЕБС-ийн 5, 9, 11-р ангиудын төгсөлтийн шалгалтын дундаж 99.95 хувьд байгаа нь өмнөх оныхоос 1.2 хувиар өссөн байна.

2009 онд зохиогдсон улсын төрөлжсөн олимпиадад 45 багш, сурагчид оролцож, 21 медаль хүртсэн нь өмнөх оныхоос 1.5 дахин өссөн байна.

Засгийн газраас цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын нормативыг шинэчлэн тогтоосны дагуу 2009 оны 1-р сараас эхлэн хоолны зардлыг төрөөс бүрэн хариуцан санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлснээр манай аймагт хүүхдийн хоолны зардал 206.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хүүхэд эцэг, эхчүүдийн талархлыг хүлээж байна. Гэвч хүүхдийн хоол хүнсэнд баталгаатай, аюулгүй, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх, түүний хадгалалт, хүүхдийн хоногийн хоолны норм, шимт бодис, илчлэгийн хэрэгцээнд нийцсэн хоол хүнс хэрэглэхэд байнгын хяналт тавьж ажиллах, хүүхдийн хоол тэжээлд хуваарилагдсан төсвийг зориулалтын дагуу үр өгөөжтэй зарцуулах, тендерт шалгарч буй компаниудад хяналт тавих, холбогдох зохион байгуулалтын ажлыг эрчимжүүлэх шаардлага урьдын адил байсаар байгаад онцгой анхаарал хандуулах ёстой байгаад дүгнэлт хийж, заавар зөвлөлгөө өгч, хяналт тавьж ажиллаж байна.

ЕБС-ийн 1-2-р ангийн сурагчдын сурах бичгийг 100 хувь, 11 жилийн 4-7-р ангийн сурагчдын сурах бичгийг 40-70 хувь, ахлах ангийн сурах бичгийн 20 хүртэлх хувийг төрөөс үнэ төлбөргүй хангаж, нийгмийн эмзэг бүлгийн 2900 хүүхдэд хичээлийн хэрэглэлийг үнэ төлбөргүй тавьж олгосон нь хүүхэд бүр тэгш суралцах, боловсролын үйлчилгээг тэгш авах эрхийг хангахад чиглэсэн арга хэмжээ төдийгүй өрх, гэр бүлд оруулсан тодорхой хөрөнгө оруулалт болж байна.

Эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэх зорилгоор Дархан сумын 1-8 дугаар багийн иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн 2 дугаар төвд зүрх судас, дотор, чих, хамар хоолой, дотоод шүүрэл, нүд, шүдний нарийн мэргэжлийн эмч нарын кабинет, боолт, нөхөн сэргээх, лабораторийн шинжилгээнүүд зэрэг 14 төрлийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлж, тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 107575 иргэд хамрагдахын хамт өрхийн эмнэлгүүдийг ажлын 6 өдөрт шилжүүлэн ажиллуулж байна.

Дархан сумын хэмжээнд 5 өрхийн эмнэлэгт түргэвчилсэн тестийн аргаар цусанд сахар илрүүлэх, цус багадалтыг тодорхойлох зэрэг үйлчилгээг хийж хэвшүүлж эхлээд байна.

Орхон, Хонгор, Шарын гол сумд болон Дархан сумын Мангирт хорооны иргэдэд эрүүл мэндийн даатгалаар үйлчилдэг эмийн санг шинээр нээж ажиллуулсан нь иргэд хөнгөлөлттэй үнээр эм авах боломж бололцоогоор хангагдлаа.

Томуугийн А хүрээний H1N1 вирусийн халдварт өвчин гарч, аймгийн хэмжээнд 21 өвчний тохиолдол бүртгэгдэж, уг өвчнийг эмчлэх, урьдчилан сэргийлэх, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авах, яаралтай тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм, эмийн бэлдмэлээр хангах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зэрэг арга хэмжээнүүдийг дэс дараатай шуурхай авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Улсын төсвөөс 105.0 сая, Олон улсын болон хандивлагч байгууллагуудаас 46.0 сая, орон нутгийн төсвөөс 9.0 сая, нийт 160.0 сая төгрөг зарцуулсны үр дүнд

өвчний дэгдэлт буурч, өвчлөлийн тоо цөөрч, халдварт өвчнийг тодорхой түвшинд барьж ажилласнаар тархалт, дэгдэлт тодорхой хүрээнд барьж ажиллаж чадлаа.

Хүн амын дунд хурдацтай тархаж буй хавдрын өвчнийг оношлох, эмчлэх зориулалтаар 5,8 сая төгрөгийн үнэ бүхий аппарат, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний тасгийн тохижилтод 3,5 сая, төрөх тасгийн эхийн болон нярайн цагаан хэрэглэл зэргийг бүрэн шинэчлэхэд 18,0 сая төгрөгийг тус тус зарцууллаа.

Мөн Нэгдсэн эмнэлгийн хагалгааны тасаг, эмнэлгийн багаж хэрэгслийн ариутгалын өрөөг стандартын шаардлагад нийцүүлэн бүрэн засварлалаа.

Түргэн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс бүрэн тоноглогдсон 2 автомашинаар парк шинэчлэлтийг хийлээ.

Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмчилгээ оношилгооны стандартыг шинэчлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, шаардлагагүй тарилгыг бууруулах, эмийг зохистой хэрэглэх чиглэлээр тогтмол сургалт явуулсны үр дүнд эм тарианы тасалдлыг 95% хүртэл буурууллаа.

Нэгдсэн эмнэлэг нь шаардлагатай 360 нэр төрлийн эм, эмийн бэлдмэлийн 90 хувийг хангаснаар өвчтөн хувиасаа эм гаргах, эмийн тасалдалттай холбоотой гомдол буурч, иргэдийн сэтгэлд нийцсэн ажил боллоо.

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, дэмжих зорилгоор “Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн”-д өглөө бүр сайн дураараа биеийн тамираар хичээллэж байгаа иргэдэд хийн дасгалыг мэргэжлийн багш зааж, арга зүйн зөвлөлгөөг тогтмол өгч ажилласны үр дүнд энэ арга хэмжээнд 60 гаруй иргэд тогтмол хамрагдах болсон нь иргэдийн хүсэл сонирхолд нийцсэн арга хэмжээ боллоо.

2009 онд улсын аварга шалгаруулах насанд хүрэгчдийн болон өсвөр үеийн сагс, гар бөмбөгийн тэмцээнийг анх удаа аймагтаа зохион байгуулж, энэ арга хэмжээнд 7.1 сая төгрөг зарцууллаа.

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжид 82433 хүн хамрагдаж 7.3 тэрбум төгрөг олголоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд 151 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж, 494 ажлын байр шинээр бий боллоо.

Тайлангийн хугацаанд 532 иргэнийг мэргэжил олгох сургалтанд хамруулж, 356 иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдлаа.

Аймгийн даатгалын сангаас өндөр настан, тахир дутуу, тэжээгчээ алдсан нийт 11.2 мянган тэтгэвэр авагчдад 12.4 тэрбум, даатгуулагчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг 2.4 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлээд байна.

## **2.Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бодлогын талаар**

Эдийн засгийн хүндрэл бэрхшээл тулгарч байгаа хэдий ч үйлдвэрлэлийн салбарт 2.5 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж “Поликом” ХХК-ий сүү боловсруулах үйлдвэр, “Алтан тос” ХХК-ий ургамлын тосны үйлдвэр, “Шарын гол энерго” ХХК-ийн коксжсон нүүрсний үйлдвэрүүдийн техник тоног төхөөрөмжийн угсралт үндсэндээ дуусч эргэлтийн хөрөнгийн зээл хөөцөлдөх ажиллагаа явагдаж байна.

Үйлдвэржүүлэлтийг дэмжих жилийн хүрээнд “Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-г байгуулж, 3 жилийн хугацаатай сарын 1.0 хувийн хүүтэй зээлийн чиглэлийг тогтоож, сонгон шалгаруулах журмаар шалгарсан 36 төсөлд 763,2 сая төгрөгийн зээл олгосны дүнд 190 ажлын байр шинээр бий боллоо. Монгол-Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн бүс нутгийг хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 12 байгууллагад 300,0 сая төгрөгийн батлан даалтыг гаргаж өглөө.

МҮХАҮТ, Германий техник хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Дархан, Сэлэнгийн бүс нутагт хүнсний ногоо, мод, ноос боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын дунд байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, үйлдвэрлэлийн хаягдлыг бууруулах, цэвэр үйлдвэрлэл эрхлэх мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор “Байгаль орчинд

ээлтэй, үр ашигтай үйлдвэрлэлийн арга технологийг нэвтрүүлэх уралдаан"-ыг зохион байгуулж шалгарсан 1 иргэн, 2 байгууллагыг Нидерланд вант улсад туршлага судлуулсан нь жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжсэн ажил боллоо.

Бизнесийн хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус 5 байгууллагаас сургалт зохион байгуулж, сургалтад 500 гаруй иргэд, бизнес эрхлэгчид хамрагдлаа.

Манай аймаг "Төвийн бүсийн түншлэл – Дархан-2009" үзэсгэлэн худалдааг анх удаа зохион байгуулж, 6 аймгийн 90 гаруй бизнес эрхлэгчид оролцож, төвийн бүсийн бренд 6 бүтээгдэхүүнийг шалгаруулж, мөн бүсийн зөвлөлийн хуралдаанд "Төвийн бүсийн бренд бүтээгдэхүүнд хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг хэлэлцүүлэн батлуулсан нь үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндэс бий болсон гэж үзэж байна. Монгол улсын "Манлай үйлдвэр"-ээр "Дархан-Дээжис" ХХК шалгарсан амжилт үзүүллээ.

ХАА-н үйлдвэржүүлэлтийн хувьд 2009 он таатай жил боллоо. Уринш боловсруулах, атаршсан талбайг эргэлтэнд оруулах зорилгоор 2009 онд аймгийн хэмжээнд 12654 га-д уринш бэлтгэсэн нь өмнөх оныхоос 1887.8 га нэмэгдсэн ба нийт тариалангийн эргэлтийн талбайн ашиглалт 72.6 хувь буюу 23.4 мянган га-д хүрээд байна.

2009 онд аймгийн хэмжээнд үр тариа 8,5 мянган га 9.6 мянган тонн буюу га тутмаас 10.0 цн, төмс 1,02 мянган га 13.4 мянга тонн, хүнсний ногоо 0.6 мянган га 8.5 мянган тонн, малын тэжээл 42.5 тн, техникийн ургамал 560 тонныг тус тус хураан авснаар аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг үр тариа 72.7 хувь, төмс 300 хувь, хүнсний ногоо 140.2 хувиар хангах боломж бүрдлээ.

"Атрын 3 дахь аян" хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөс Хонгор суманд 210 га газрын услалтын систем байгуулахад 394.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр аймгийн хэмжээнд 1700 га талбайд усалгаатай тариалан эрхлэх боломж

бүрдсэн ба 4 суманд Агропарк байгуулж, 30 тоннын багтаамжтай зоорь, 6х20 метрийн харьцаатай хүлэмж, бага оврын трактор иж бүрнээр нь 3 суманд олгосноор сумдын агропаркуудын үйл ажиллагаа тогтворжлоо.

Малыг эрүүлжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж, халдварт ба паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 1.2 сая толгой малыг хамруулж, энэ ажилд 31.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцууллаа.

Хонгор сумын “Бор залаа” өрхийн аж ахуй, “Нарс ээж” ХХК-иуд олон улсын хөтөлбөр, төслийн дэмжлэгтэйгээр сүү боловсруулах 2 үйлдвэр шинээр ашиглалтад орууллаа.

Япон улсын Жайка ОУБ-ын “УСАН ХАНГАМЖИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛТ” / 2009-2011 онд хэрэгжих / төслөөр “Дархан-Ус суваг” ХК-д 9.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж эхлээд байна. Энэхүү төсөл хэрэгжснээр эрчим хүчний хэмнэлтэт горимоор Дархан хотын иргэдийг ундны цэвэр усаар хангах нөхцөл бүрдэх төдийгүй 5, 6 дугаар багийн гэр хорооллын иргэд төвлөрсөн системийн усаар хангагдах нөхцөл, техник тоног төхөөрөмжийн орчин үеийн технологид шилжих болно.

Шарын гол сумын иргэдийн цэвэр усны хэрэгцээг хангахын тулд 90.0 сая төгрөгийн усны эрэл хайгуулын ажлыг “Усны байгууламж” ХХК, 40.0 сая төгрөгийн ажлын зураг төсвийг “Инж байгууламж” ХХК-иудаар тус тус гүйцэтгүүлэн бэлэн болгосон бөгөөд 2010 оны эхний улиралд 540.0 сая төгрөгийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны шугамаар тендер зарлах бэлтгэл ажил хангадлаа.

Шарын гол сумын “Дулаан-Шарын гол” ХК-ийг Төрийн өмчит компани болгон өөрчлөн зохион байгуулж, Шарын голын уурхайд төлөх олон жилийн хуримтлагдсан 491.0 сая төгрөгийн өрийг Засгийн газарт хүсэлт тавьж

шийдвэрлүүлсэн бөгөөд тус байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад орон нутгийн төсвөөс 65.0 сая төгрөгийн дэмжлэг туслалцаа үзүүллээ.

Дарханы Дулаан Цахилгаан Станцаас Дархан сумын төв хүртэлх 4.7 км урттай дулааны төв магистраль 800-гийн шугамыг 6.4 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад бүрэн оруулж ажилаж байна.

2009 онд “СӨХ-ын ажлыг сайжруулах, цаашид авах арга хэмжээний талаар” сургалт семинарыг зохион байгуулж, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, 40 СӨХ-дыг 28 болгон цомхотгож үйл ажиллагаагаа цаашид хэвийн явуулах нөхцөл бололцоог бүрдүүллээ. Урьд жилүүдэд СӨХ-тэй холбоотой иргэдээс гардаг гомдол, санал зохих ёсны хариу өгсөн бодитой ажил хийгдлээ гэж үзэж байна. Аймгийн Захирагчийн алба Монгол Улсын СӨХ-ны дээд зөвлөлтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.

### **3. Байгаль орчны бодлогын талаар**

Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Морин хуур цогцолбор, аюулгүйн тойрог, Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд нөхөн тарилтаар 5 төрлийн 2810 ш модыг сийрэгжүүлж, шинээр 5719 ш суулгац тарьж, нийт 20000 гаруй модыг хэлбэржүүлж, мод үржүүлгийн талбайд 23200 ширхэг улиасны үрсэлгээг бэлтгэж, үүнд нийт 9.5 сая төгрөг зарцууллаа.

Аймгийн хэмжээнд нийт 329 га талбайд 562611 ширхэг шилмүүст болон бутлаг ургамлын ойжуулалтын ажлыг 42.0 сая төгрөгийн Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор 3 булаг шандыг тохижуулаа.

Дархан сумын 5, 6, 7, 15 дугаар багуудын үерийн далан, шуудууны 3635 м3 хог хаягдлыг цэвэрлэн зайлуулж, 6, 7 дугаар багуудын хур хогийг цэвэрлэхэд 60 хүнийг түр ажлын байраар хангаж 7.2 сая, 2200 золбин нохой устгахад 11.0 сая төгрөгийг тус тус зарцууллаа.



Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 6264 иргэнд 731.9 га газар өмчлүүлээ.

Дархан суманд амины орон сууцны зориулалтаар 4.4 га, үйлчилгээний зориулалтаар 1.31 га газрын газар эзэмших эрхийн дуудлага худалдааг 3 удаа зохион байгуулж, 67.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Дархан сумын 28 сууц өмчлөгчдийн холбоодод орчны газрыг ашиглуулах, кадастрын зураглал, бүртгэлийг бүрэн хийж дуусган, газрыг СӨХ-дын оршин суугчдад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж өгөхөд бэлэн байна.

Монгол Улсын Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль болон Барилгын тухай хуулиудыг ноцтой зөрчин Дархан сумын нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй баригдсан 110 гаруй барилга, байгууламжийн 49 хашаа, 14 граж, 4 ТҮЦ, 2 вагончикийг буулган нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авсан ба цаашид дээрх хуулиудын хэрэгжилтийг хангуулахад онцгой анхаарч ажиллах болно.

#### **4. Батлан хамгаалах, гамшгаас хамгаалах бодлогын талаар**

2009 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар 6993 иргэнийг оруулж, цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн татах хяналтын тоог 100 хувь биелүүллээ. Гэрээт цэргийн албаны сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу явуулж, 12 иргэнийг тэнцүүлэн цэргийн ангид хуваариллаа.

Цэргийн албанд эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх арга хэмжээнд 319 иргэнийг хамруулж, 216 иргэнийг эрүүлжүүллээ.

Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах ажлын хүрээнд 4.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

2009 онд “Шувууны томуу, хүний томуугийн цар тахалтай тэмцэх чадавхийг сайжруулах төсөл”-ийн багийн сургалтын танхимыг шинээр тохижуулж, аймгийн

хэмжээнд Гамшгаас хамгаалах өдөрлөгийг зохион явуулж, энэ арга хэмжээнд 2235 иргэнийг хамрууллаа.

Аймгийн Онцгой байдлын газрын Аврах, гал унтраах ангиуд нь тайлангийн хугацаанд 146 гал түймрийн дуудлага хүлээн авч, аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдэд учирч болох 216.9 сая төгрөгийн өмч, хөрөнгө авран хамгаалж, галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор давхардсан тоогоор 944 объект, аж ахуйн нэгж, байгууллага, 26076 айл өрхөд шалгалт хийж, 3261 зөрчлийг арилгууллаа.

## **5. Эрх зүйн бодлогын талаар**

Хууль тогтоомжийн бичмэл санг 743 эрх зүйн актуудаар баяжуулан, уг сангаас давхардсан тоогоор 2240 иргэн, 54 аж ахуйн нэгж, байгууллагад хууль зүйн зөвлөгөө өглөө.

Монгол улсын Авлигатай тэмцэх газар, Иргэний нийгмийн зөвлөл, аймгийн Засаг дарга нарын хооронд орон нутгийн төр, захиргааны байгууллагын нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор хамтран ажиллах гэрээг 4 жилийн хугацаатайгаар байгуулж, хэрэгжүүлж байна. Аймгийн ГХУСЗЗөвлөлийн орлогоос тодорхой санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2009 онд 608 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 5.5 хувиар буурсан дүнтэй байна.

Иргэдэд цагдаагийн ажил үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор Цагдаагийн газрын автопаркыг аймгийн төсвөөс 3 автомашинаар нэмэгдүүлж, Дархан сумын алслагдсан Мангирт, Тосгон, 5, 6, 7 дугаар багуудад 3 чиглэлд 24 цагаар хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулж, нийт 1785 зөрчлийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Энэ нь ард иргэдийн сэтгэл таашаалд нийцсэн бодитой ажил болж гэмт хэргийн гаралт, бууралтад тодорхой хэмжээгээр нөлөөллөө.

“Хяналтын нэгдсэн систем”-ийг Дархан хотын хэмжээнд байгуулахаар Турк улсын тусламжтайгаар “МОБИСИ” системийн зураг төслийг боловсруулан 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар иж бүрэн хяналтын нэгдсэн системд орох

нөхцөл бүрдлээ. Ингэснээр Дархан хот бүрэн хяналтын системд хамрагдаж, гэмт хэрэг эрс буурах нөхцөл бүрдэх юм. Энэ ажилд Засгийн газраас 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2010 онд төлөвлөсөн болно. Одоо гэрээ хэлцэл хийгдэж ажил эхлэх болно.

Архидан сонтуурахтай тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийгмийн дэг журмыг хангуулах зорилгоор хууль хяналтын байгууллагуудтай байнга хамтран ажиллаж байна. Тухайлбал : “Архигүй л бол гоё доо” сэдэвт 45 хоногийн аян, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлье иргэдээ” нэг сарын аяныг тус тус зохион байгуулж, уг арга хэмжээнд 2243 ажилтан, албан хаагч, оюутан сурагчид хамрагдлаа.

Аймгийн хэмжээнд иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, авлигаас ангид, хүнд суртал чирэгдэлгүй болгох зорилгоор “Нэг цонхны үйлчилгээ”-нд Монголын Нотариатчдын танхимын Дархан-Уул дахь салбартай гэрээ байгуулан нотариатч нарыг ажиллуулж байна.

Дархан-Уул аймгийн Сум дундын шүүхийн ерөнхий шүүгч, Цагдаагийн газрын дарга нарын ажиллах нөхцөл баталгааг хангах зорилгоор албан тушаалын орон сууц худалдан авахад 41.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгон дэмжлэг үзүүллээ.

Согтууруулах ундаа үйлдвэрлэдэг, худалддаг, түүгээр үйлчилдэг тусгай зөвшөөрөл бүхий 262 аж ахуйн нэгж, байгууллагад аймгийн Мэрэгжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Татварын хэлтэс хамтран шалгалт хийж, зөрчил гаргасан 5 аж ахуйн нэгж байгууллагын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны харъяанд Засгийн газрын тогтоолын дагуу улсын хэмжээнд “Жишиг хорих анги” бий болгох зорилгоор жирийн дэглэмтэй төвлөрсөн хорих 455 дугаар анги шинээр зохион байгуулагдсан ба тус алба нь гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг 48.5 хувьд, мөнгөн дүнг 55.7 хувьд тус тус хүргэлээ.

МУЗГ, Ерөнхий сайдаас дэвшүүлсэн “Төр иргэнийг холбосон бүртгэлийг төгөлдөршүүлэх”, “Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох” зорилтын хүрээнд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Иргэний бүртгэлийн улсын нэгдсэн сүлжээ” төслийг 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн иргэний бүртгэлийн үйл ажиллагааг ИБМУТөвтэй шилэн кабелиар шууд холбож, тоног төхөөрөмж суурилуулсан. Монгол Улсын Засгийн газраас “Төр иргэнийг холбосон бүртгэлийг төгөлдөршүүлэх ажлын хүрээнд 2.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Иргэний бүртгэлийн тасаг нь Улсын бүртгэлийн ерөнхий газар болон 21 аймгийн УБХ-тэй Online сүлжээнд холбогдлоо.

Улсын нэгдсэн сүлжээнд Шарын гол, Орхон, Хонгор сумдаас бүртгэлийн ХААТР, маягтыг шивэх, баталгаажуулах ажлыг 2009 оны 6 дугаар сараас эхлүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2009 оны 82 дугаар захирамжаар иргэний бичиг баримтгүй иргэдийг үнэмлэхжүүлэх, зөрчлийг арилгах зорилгоор “Нэг сарын аян”-ыг зохион байгуулж, уг аянд аймгийн хэмжээнд 91578 иргэн хамрагдахаас 75997 иргэн буюу 82.9% нь хамрагдаж, огт баримт бичиггүй, орон нутгийн шилжүүлэггүй, иргэний үнэмлэх огт аваагүй зэрэг 702 зөрчлийг илрүүлэн арилгаж, зөрчил гаргасан 2167 иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу 8.6 сая төгрөгийн торгууль төлбөр ногдуулсан ба тус хэлтэс нийт дүнгээр 76.2 сая төгрөгийг улсын төсөвт оруулсан байна.

2009 оны жилийн эцсийн байдлаар огт иргэний үнэмлэх аваагүй 248 иргэнийг үнэмлэхжүүлж, шинээр 2047, дахин 2985, 25, 45 насны сунгалт 2895, нийт 9256 иргэнд иргэний үнэмлэх олгож, 10673 иргэнд хаягийн хөдөлгөөн хийж, 4033 иргэнийг шилжин ирснээр 3944 иргэнийг шилжин явсны бүртгэлийг хийж, зөрчил гаргасан 2909 иргэнд хуулийн дагуу 12.3 сая төгрөгийн торгууль ногдууллаа.

## **6. Төрийн удирдлагын чиглэлээр**

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн эрхэм зорилгыг “Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, иргэдийн амьдрах

орчныг сайжруулах, төрийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах” чиглэлээр тодорхойлж, үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын бодлого боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулж, зохицуулах үйл ажиллагааны үе шат бүрт хийгдэх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын цар хүрээг өргөжүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн бүтцэд Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг”-ийг шинээр байгуулж, 5 хэлтэс, 4 сум, 20 агентлагын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, “Зөвлөмж” боловсруулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.

Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, сум, агентлагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний 45 мэргэжилтнийг хамруулсан сургалт зохион байгуулсан ба одоогийн байдлаар 4 сум, 20 агентлагын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний 24 багийн бүрэлдэхүүнд 80 гаруй мэргэжилтэн ажиллаж байна.

Манай аймаг “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт”, “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д суурилсан аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын 50 баримт бичиг боловсруулж баталгаажуулснаар аймгийн хөгжлийн өнөөгийн болон хэтийн төлвийг тодорхойлох эрх зүйн үндэс хангагдлаа.

Тайлант хугацаанд аймгийн ЗДТГ-ын хэлтэс, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагуудын үйл ажиллагааны чиг үүргийг боловсронгуй болгох, тэдгээрийн ажлыг нягтруулж, хариуцлагыг өндөржүүлэх, хүнд суртлыг арилгах зарчим баримталж ажилласны зэрэгцээ төсвийн сахилгыг чанд мөрдөх, үргүй зардал гаргахгүй байх талаар тодорхой чиглэл, үүрэг даалгавар өгч ажиллалаа.

2009 онд аймгийн ҮЭХ, Ажил олгогч эздийн холбоотой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, цалин хөлс, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн удирдлага, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр “Хөдөлмөр,

нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр"-ийг байгуулан хамтарсан ажлын төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллалаа.

Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт 74 байгууллага хамрагдан 97.6%-тай дүгнэгдэж, аймгуудын дунд улсын хэмжээнд 1 дүгээр байр эзэллээ.

2009 онд анх удаа “Багийн Засаг дарга нар болон олон нийтийн байцаагч, нийгмийн ажилтнуудын нэгдсэн сургалт семинар”-ыг зохион байгуулж, “Багийн хөгжлийн сан байгуулах, түүнийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”, “Сумын багуудад хэсгийн ахлагч ажиллуулах үлгэрчилсэн журам”-уудыг шинээр боловсруулж, хэсгийн ахлагчийн урамшууллын зардалд 2.7 сая, мөн Дархан сумын 6,7 дугаар багийн гэр хорооллын гудамжуудыг хаягжуулахад 3.3 сая, Дархан, Орхон, Хонгор сумдын багуудыг шаардлагатай орчин үеийн техник хэрэгслээр хангахад 15.5 сая төгрөгийг тус тус зарцууллаа.

2009 онд ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хоттой нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёлын салбарт харилцан ашигтай ажиллах гэрээг 5 жилийн хугацаатай шинэчлэн байгуулсан ба Лаос улсын Сэконг аймагтай хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа.

Цаашид БНСУ-ын Самчук хоттой ах дүү хотын харилцаа тогтоож, ӨМӨЗО-ны Хөх хот, Бугат зэрэг хотуудтай үйлдвэр, хот тохижилт, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуйн харилцааг өргөжүүлэх, харилцан ашигтай гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтран ажиллах ажлын эхлэлийг тавиад байна. */Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын гадаад харилцааны 2009 оны тайланг хавсаргаав./*

## **2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал**

Аймгийн ЗДТГ-ын даргын 2009.01.06-ны өдрийн 01 дүгээр тушаалаар “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулах ТЗУХ-ийн даргаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан, хөтөлбөр боловсруулах судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсний үр дүнд аймгийн ЗДТГ-ын даргын

2009.06.24-ны өдрийн 62 дугаар тушаалаар аймгийн ЗДТГ-ын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /2009-2018 он/”-ийг батлуулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, 2009 онд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Мөн бүх сум, агентлагуудад хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар чиг үүрэг, зөвлөмж өгч ажиллалаа.

**Нэг. Аймгийн ЗДТГ-н албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд:**

2009 онд аймгийн ЗДТГ-ын төрийн албан хаагчдын цалин хөлс, нэмэгдлийг зохих хууль тогтоомжийн дагуу олгож, энэ арга хэмжээнд 203.575 сая төгрөг зарцууллаа. Мөн Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор техник хэрэгсэл худалдан авах зардалд 6.15 сая, 37 албан хаагчид /унаа бүхий албан тушаалтнуудаас бусад/-ын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд 6.37 сая, ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явж амарсны зардалд 1.11 сая, ТАХ-дын дунд зохион явуулах тэмдэглэлт үйл явдал, аймгийн ЗДТГ-т харъяалагддаг 50 ахмадуудад Олон улсын ахмадуудын баярын өдрөөр хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж олгох болон урлаг, спортын чиглэлээр 10 төрлийн арга хэмжээний зардалд 5.56 сая, өндөр насны тэтгэвэрт 10.1 сая, Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын шагналаар шагнагдсан албан хаагчдын урамшуулалд 0.58 сая, гэр бүлд шинээр мэндэлсэн хүүхдийн урамшуулалд 0.06 сая, Их, дээд сургууль, коллежид элсэн суралцаж байгаа 12 оюутны сургалтын төлбөрийн зардалд 5.1 сая, бүх албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх 12 төрлийн үзлэг шинжилгээ, оношлогоонд хамруулах зардалд 0.25 сая, гачигдал, зовлон тохиолдсон албан хаагчийн ар гэрт нь буцалтгүй тусламж үзүүлэх зардалд 0.42 сая, гадаад томилолтын зардалд 2.21 сая, дээрх арга хэмжээнүүдэд нийт 38.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор 5 албан хаагчийг орон сууцны, 20 албан хаагчийг цалингийн зээлд тус тус хамрууллаа.

Буриад улсын Улан-Удэ хотын “Байгалийн долгио” хүүхдийн зусланд Тамгын газрын албан хаагчдын 25 хүүхэд, 2 багшийг 14 хоног амраах зардалд 2.55 сая төгрөг зарцууллаа.

### **Хоёр. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд :**

Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын 2009 оны “Сургалтын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх 33 арга хэмжээ төлөвлөж ажилласан ба Төрийн захиргааны магистрын “Улирал”-ын сургалтад 2, менежерийн “Улирал”-ын сургалтад 3, сертификатын сургалтад 1, Засгийн газрын захиалгат богино хэмжээний сургалтад 36, нийт 42 албан хаагч хамрагдаж, эдгээр сургалтуудын арга хэмжээний зардалд 2.7 сая төгрөг зарцууллаа. Аймгийн ЗДТГ-ын даргын баталсан хуваарийн дагуу “Мэдээллийн цаг”-ийг 39 удаа зохион байгуулж, уг арга хэмжээнд Тамгын газрын нийт албан хаагчид бүрэн хамрагдлаа.

2009 онд Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 4 албан тушаалын сул орон тоонд 9 иргэн бүртгүүлснээс 7 иргэн шалгалтад орж тэнцэн, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын нөөцийн жагсаалтад, мөн төсвийн байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх дарга /захирал, эрхлэгч/-ын албан тушаалын сонгон шалгаруулалтад 6 албан тушаалын сул орон тоонд 46 иргэн бүртгүүлж, 41 иргэн шалгалтад орсноос 9 иргэн тэнцэж нөөцийн жагсаалтад тус тус бүртгэгдлээ.

Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ албан тушаалд шинээр ажилтан элсүүлж авахаар 32 сул ажлын байрыг зарлаж, төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2 удаа зохион байгуулан, 564 иргэнийг бүртгэн авч шалгаруулалтанд оруулж, тэнцсэн 150 иргэнийг нөөцийн жагсаалтад бүртгэлээ. */Аймгийн ЗДТГ-ын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн 2009 оны хэрэгжилтийг хавсаргаав./*

### **3.Төсөв, санхүүгийн ил тод байдал**



## **Санхүү, эдийн засгийн бодлого, төсвийн гүйцэтгэлийн талаар**

2009 онд орон нутгийн төсвийн орлого 5.7 тэрбум төгрөг байхаас 5.7 тэрбум төгрөг болж, 100.0 хувиар биелүүлж, улсын төсөвт 2.7 тэрбум төгрөг төвлөрүүллээ.

“Татвар төлөгчдийн өдөр”-ийн арга хэмжээний хүрээнд 164 аж ахуйн нэгж, байгууллага, 2009 иргэнийг шинээр татвар төлөгчөөр бүртгэн татварын бааз суурийг өргөтгөлөө.

2008 оны тайлангаар 263.0 сая төгрөгийн татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд 1469 татвар төлөгч, иргэн хамрагдаж, 33 иргэнд 21.6 сая төгрөгийг буцаан олголоо.

Иргэдийн амьдрах орчинг сайжруулах, дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэх зорилгоор дараах тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн нь ард иргэдийн сэтгэлд хүрсэн бодит ажил болж чадлаа.

- Дархан сумын 11-16 дугаар баг буюу орон сууцны 1, 6 дугаар хорооллын /хуучин, шинэ хороолол/ доторхи 4 мянган м<sup>2</sup> замыг засварлахад 74.4 сая төгрөг зарцууллаа.
- Мөн дээрх багуудын /хуучин, шинэ хороолол/ гэрэлтүүлгийг 105.9 сая төгрөгөөр сэргээн засварлаж, 135 ширхэг гэрэлтүүлэг тавьж бүрэн гэрэлтүүлэгтэй болгосон.
- Мөн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд 7.6 сая төгрөг зарцуулан 9 мянган ширхэг модыг иргэдийн оролцоотойгоор тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүллээ.
- Дархан сумын 13-16 дугаар баг буюу орон сууцны хуучин хороололд байрлуулахаар 16.4 сая төгрөгийн өртөг бүхий хүүхдийн хөдөлгөөнт тоглоомуудыг авчраад байгаа бөгөөд хүйтрэлтээс хамаарч суурилуулах ажил хойшлогдсон ба ирэх жил суурилуулахаар төлөвлөөд байна.

- Аймгийн хэмжээнд 3400 м<sup>2</sup> талбай бүхий 5 давхар орон сууцны 6 байрны дээврийн засварын ажлыг 57.2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.

Мөн 4 дүгээр хороолол буюу 9 дүгээр багийн нутагт 183.0 сая төгрөгөөр автомашины зогсоол, замын засвар, өргөтгөлийн ажлыг хийлээ.

Энэ онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2.4 тэрбум төгрөгийн ажлууд хийгдлээ. Хөрөнгө оруулалтыг салбараар нь авч үзвэл:

- Эрүүл мэндийн салбарт 110.0 сая төгрөг,
- БСШУ-ны салбарт 240.0 сая төгрөг,
- Зам, тээвэр, хот байгуулалтын салбарт 1637.5 сая төгрөг,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 83.1 сая төгрөг,
- Замын сангийн хөрөнгө оруулалтаар 180.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдлээ.

2009 онд хотын дотор нийт 4.87 км асфальт бетон хучилттай зам шинээр тавьж, 1.6 тэрбум төгрөгийг зарцууллаа.

Бурхантай толгой, Морин хуурын цогцолбор, Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн, Дүүжин гүүр зэрэг барилга, объектуудын засвар үйлчилгээнд 24.9 сая төгрөгийг зарцууллаа.

- Төсвийн хөрөнгийн зарцуулалт, зардал хэмнэх, өр авлагыг бууруулах чиглэлээр зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын үр дүн:

Аймгийн хэмжээнд төсөв санхүүгийн талаар дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн дагуу улсын төсөв, төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлэн зах зээлийн хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай ашиглах, төсвийг дунд хугацаагаар төлөвлөх, орон нутгийн төсвийн орлогын найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэх, улмаар татварын орлого хуваарилах шинэ арга хэрэгслийг нэвтрүүлэх, төсвийн

зарлагын удирдлагыг сайжруулах, төсвийн эрх захирагч нягтлан бодогч нарын хүлээх хариуцлагыг өндөржүүлэх, төрийн сангийн тогтолцоо, төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн удирдлага зохион байгуулалтын томоохон арга хэмжээнүүдийг дэс дараатай авч хэрэгжүүллээ.

- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 104.1 хувиар биелүүллээ.
- Төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 2736.1 сая төгрөгөөр буюу 100 хувиар биелүүлсэн.
- Санхүүгийн тооцоолох компанитай хамтран ажилласнаар 48 төсвийн байгууллагын санхүүгийн программ хангамжаа шинэчилж, 10 байгууллага нэмэлт өөрчлөлт орууллаа.
- “Итгэлийн зээл”-ийн гэрээний нөхцөлийн дагуу Орхон сумаас 2.1 сая, Хонгор сумаас 6.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс татан төвлөрүүлж, зээлийн өрийг 100 хувь барагдпууллаа.
- “Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг батлах тухай” Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг байгуулага бүрээр /зардлын дэлгэрэнгүй мэдээлэл/ гаргаж, “Мэдээллийн самбар”-т сар бүр байрлуулж хэвшсэн.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, хагас, бүтэн жилийн баланс тайланг аймгийн хэмжээнд 4 сум, 107 төсөвт байгууллагаас хүлээн авч нэгтгэн, жилийн эцсийн баланс тайланг Plastic программаар гаргалаа.

#### **4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал**

##### **А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах 2009 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2008 оны 10 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Дархан-Уул аймагт 2009 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 нэр төрлийн 2012.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн бөгөөд үүнээс 2 нэр төрлийн 1797.5 сая төгрөгийн ажлын худалдан авах ажиллагааг өмнөх онд зохион байгуулсан ба 2009 онд хийхээр төлөөвлөсөн уг ажлууд бүрэн хийгдсэн.

БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 5 нэр төрлийн 99.6 сая, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 2 нэр төрлийн 109.6 сая төгрөгийн засварын ажлууд хийгдлээ.

#### **Б. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4 нэр төрлийн 150.0 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 180.4 сая төгрөгийн ажлууд бүрэн хийгдлээ.

- Сангийн яамнаас зөвшөөрөл авах шаардлагатай ажил үйлчилгээ байхгүй байсан,
- Төлөвлөгөөнд тусгагдаагүйгээр худалдан авах ажил, үйлчилгээ хийгдээгүй,
- Тендертэй холбоотой ямар нэгэн гомдол, ямар нэгэн зөрчил гараагүй.

#### **В. Худалдан авах ажиллагааны талаар:**

- Аймгийн ЭМГ, ЦГ тухайн бараа, ажил, үйлчлгээг худалдан авах ажиллагааны захиалагчийн үүргийг гүйцэтгэсэн.
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулж явуулах талаар төсөвт байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөлгөө өгч ажиллалаа.

### **Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, хэрэгжилтийн үр дүн:**

- Дархан-Уул аймгийн 2009 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудад захиалагчаар ажиллаж, худалдан авах ажиллагаа 100 хувь бүрэн хэрэгжсэн.

Хороолол доторх замын гэрэлтүүлгийн ажил, аймгийн Цагдаагийн газарт эргүүл хамгаалалтын автомашин худалдан авах тендер хүчингүй болж, дахин тендер зарлаж хэрэгжүүлсэн. *“Дархан-Уул аймгийн 2009 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан”-г хавсаргав./*